

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Даржаагийн Гончиг	Дугаар	L019
Оршин суугаа аймаг	Улаанбаатар хот	Оршин суугаа сум	Баянгол дүүрэг
Төрсөн газар	Дундговь аймгийн Эрдэнэдалай сум	Төрсөн он	1916
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Мэнгэтийн хийд	Сүм хийдийн дугаар	ДУХД 022
Одоогийн сүм хийд	Ламрим хийд	Сүм хийдийн дугаар	УВ 04
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 11-р сарын 9	Ярилцлага авсан хүн	Ч. Хулан



### Дундговь аймгийн Хулд сумын Мэнгэтийн хийд

Мэнгэтийн хийд 1890 хэдэн оноос эхэлж байгуулагдсан болов уу. Тэнд нь Мэнгэт гэдэг худаг байсан. Тэр худгаар тэгж Мэнгэт гэж нэрлэсэн юм. Ширгэдэггүй элбэг ус байсан юм. Дундговь аймгийн Эрдэнэдалай, Хулд хоёр сумын дунд нь байсан. Түшээт вангийн хошууны нутаг. Хийдээсээ Цагаан овоог зуны адаг сарын шинийн 5-нд тогтоолтой тахидаг байсан. Цагаан овоо том тахилгатай газар байсан юм. 1905, 1906 онд Цогчэн дуганыг барьсан. Бусад дуганыг түүнээс өмнө барьсан. Шинэхэн дуган л гэж ярьдаг байсан. Бааюу эд нар нь шинэвтэр байсан. Хятад хүмүүс ирж барьсан юм гэнэ лээ. Бааюуг Цогчэн дуганыг барих гэж л хийж байсан юм байна лээ. Аргалаар шатааж байсан гэсэн. Шохой авч байсан газар нь хийдээс урагш 30-ад км-н зайтай байсан. Дуганууд нь тоосгоор баригдсан байсан.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

1937 оны үед 20 дөнгөж гарч байсан. Мэнгэтийн хийдэд шавилан сууж байсан. Манай хийдийн ойролцоо Үнстийн хийд гэж байсан. Мөн Эрдэнэдалайн хийд гэж нэлээн том хийд байсан. Өмнөговийн Дэлгэрхангай уулын хошууны хүн. Мэнгэтийн хийд 4 дуганатай байсан нэг өртөө хийд юм. Өртөөний жас гэж нэрлэдэг байсан. Цогчэн, Манла, Сахиус, Суварганы гэсэн 4 дугантай байсан. Луусын нутагт Хэвтүүл гэж бас нэг хоёр дугантай нэг жас байсан юм.

Мэнгэтэд бүгд хурвал 100 дөхдөг тийм ламтай газар байсан юм. Цогчэн, гүрэм, Хангал, Сандуй, Дэмчиг, Дүйнхор хурдаг. Улиралд нэг Арван Хангал уншдаг байсан. Би 1932, 33 оны үед Хүрээнд ирж Дашчоймбэл дацанд суусан. Мэнгэтийн хийдэд 7, 8 настай нагац ах дээрээ очиж ном заалгаж эхэлсэн. Миний эжий миний багшийн эгч нь байсан юм.

Хоёр ловон байсан. Тэр хоёр хоёул миний багш байсан. Ням ловон, Жанцан ловон гэж байсан. Сүүлдээ Совд гэлэн гэж болсон. Унзад нь Батдэлгэр, Гончиг, гэсгүй нь Шийрав, Гонгор гэсэн лам нар байсан.

Хийдийн сахиус нь Хангал. Хэвтүүлийн гол шүтээн нь Гомбо, Мэнгэтийн хийдийнх бол Лхам, ядам нь Жигжид байсан. Ханчин дэгтэй хийд байсан. Тэр үед манайд хурж байсан хүмүүсээс надаас 4, 6 дүү хоёр хүн байгаа.

Сандуй, Жигжидийн Жанхор дүлцон хийдэг байсан. Чого Суварганы дуганд хурна. Би цанидын ном бараг үзээгүй. Арван хангал, хэдэн магтаал л үзсэн. Манай аав ч лам хүн байсан. Хайлан хурна. 45 хоног. Гэцэл сахилтай улсууд хайлан хийнэ. Доод тал нь 20-оод, дээд тал нь 30-аад хүн хайланд хурж байсан.

Майдар зуны эхэн сарын 15-нд эргэнэ. Жилдээ нэг эргэнэ. Тэргэн дээр ачаад лам нар, ардууд түрээд явдаг байсан.